| 4.1.1.2 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | - | - Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна<br>- Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | 2024 онд үүссэн Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 104 дугаартай албан бичгээр, Хотонт сумын газрын даамлын сул орон тооны захиалгыг 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 261 дугаартай албан бичгээр, Тариат сумын газрын даамлын сул орон ны захиалгыг 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 474 дугаартай албан бичгээр, Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 476 дугаартай албан бичгээр, Эрдэнэмандал сумын газрын даамлын сул орон тооны захиалгыг 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 973 дугаартай албан бичгээр, Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалыг 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 900 дугаартай албан бичгээр тус тус Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд тухай бүр хүргүүлсэн.<br>2024 оны 12 дугаар сарын байдлаар Эрдэнэбулган, Цэнхэр, Хотонт, сумын газрын даамал, кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн болон мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоо төрийн албаны тусгай шалгалтаар Хашаат сумын газрын даамлын сул орон тоо Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу шилжин ажиллах хүсэлтээр нөхөхдсөн байна. Тус газарт Тариат, Эрдэнэмандал, Өлзийт гэсэн 3 сумын газрын даамлын орон тоо нөхөхдөөгүй байгааг Төрийн албаны хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т заасны дагуу хамгийн ойрын чиг үүргийн албан хаагчаар давхар гүйцэтгүүлэн ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн 2024 онд Төрийн албаны хуулийн дагуу тусгай шалгалтаар сонгон шалгарч Төрийн албаны зөвлөлийн нэр дэвших тогтоолын дагуу томилогдсон Эрдэнэбулган, Цэнхэр, Хотонт сумын даамал Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн нийт 5 албан хаагчийг 2024 оны 07 дугаар сарын 08, 2024 оны 11 дүгээр сарын 25 гэсэн өдрүүдэд Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх арга хэмжээнд оролцуулж тангараг өргүүлсэн. | |
| 4.1.1.3 | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" /2021-2025/-ыг баталсан. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/02 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөө баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж тайланг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт 2024 оны 06, 12 дугаар саруудад газрын даргын 550, 1108 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газар, ГЗБГЗЗЕГ-т тус тус хүргүүлсэн. | |
| 4.1.1.4 | Салбарын хэмжээнд "Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Салбарын хэмжээнд Жэндерийн талаарх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/02 дугаартай тушаалын гуравдугаар хавсралтаар "Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах 2024 оны төлөвлөгөө баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж тайланг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт 2024 оны 06, 12 дугаар саруудад газрын даргын 550, 1108 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газар, ГЗБГЗЗЕГ-т тус тус хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1.5 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчлэх | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | - | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна. | Тус газрын хэмжээнд хүний нөөцийн цахим системд https://hrm.csc.gov.mn сайтыг ашиглаж байна. 2024 оны байдлаар өөрчлөлт өрсөн, шинээр ажилд орсон, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг тухай бүр бүртгэж мэдээллийг шинэчилж ажилласан. Түүнчлэн 2024 оны эхний хагас жилд албан хаагчдын цалингийн санд газрын даргын тушаалаар 2 удаа, аймгийн Засаг даргын захирамжаар 11 албан хаагчийн зэрэг дэв өөрчлөгдсөнг хүний нөөцийн цахим системд бүртгэсэн. Мөн https://hrm.csc.gov.mn цахим системийн ажил мэргэжлийн ангилалын код, ажил мэргэжил зэрэг мэдээлэл 2024 оны 04 сард албан ёсоор өөчрлөгдсөн бөгөөд тухай бүр албан хаагчдын мэдээллийг шинэчилсэн. 2024 оны эхний хагас жилд багтаан нийт албан хаагчдын АТТ-ыг цахим системд бүрэн оруулсан. | |
| 4.1.1.6 | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх | Үйл ажиллагаа | Мэдээ, судалгааны тоо | - | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын мэдээллийг тухай бүр болон хагас бүтэн жилээр гаргаж ГЗБГЗЗЕГ-ын захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн н.Ганцэцэгт хүргүүлсэн. Тус газар нь ГЗБГЗЗЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/10 дугаартай тушаалаар баталсан 41 орон тоотой үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс 2024 оны байдлаар ТЗ-36, ТҮМ-3, ТҮ-2 байна.<br>Түүнчлэн аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Хөрөнгө зарцуулах тухай” А/05 захирамжаар тус газрын барилга захиалагчийн хэлтэс 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулахаар батлагдсан. Тухайн ТҮ-ний 10 албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн цахим системд бүртгэх, хувийн хэргийн бүрдэл хангах ажлыг тухай бүр зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.2** | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **12 удаа** | **-** | **Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна.** | | |
| 4.1.2.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Мэдээллийн тоо | - | Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж баталгаажуулсан байна. | Байгууллагын цахим хуудас болон, Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал, хагас, бүтэн жилийн мэдээллийг хугацаанд нь оруулж баталгаажуулж, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг ил тод мэдээлж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 газраас худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг оруулж , батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр баталгаажуулж, тайлан , санхүү, төр хувийн хэвшлийн гэрээ, концесс, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр , авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр хугацаанд нь 151 мэдээлэл 11 сарын 30-ны байдлаар бүрэн оруулж баталгаажуулсан. | |
| **4.1.3** | **Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **1 төлөвлөгөө, 3 тайлан,** | **-** | **Төлөвлөө болон тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.** | Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн “Аймгийн 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай” А/154 дугаартай захирамжаар Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Тус газрын даргын зөвлөлийн шийдвэрээр аймгийн хэмжээнд батлагдаж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг мөрдөж хэрэгжилтийн тайланг холбогдох газар хүргүүлэхээр шийдвэрлэсэн тул газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах | Үйл ажиллагаа | Тайлангийн тоо | 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна<br>Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. | 04-ны өдрийн А/02 дугаартай тушаалд аймгаас батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр дурдсан хэрэгжилтийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 15-ны 551 дугаартай албан бичгээр ЗДТГ-т мөн өдрийн 550 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т тус тус хүргүүлсэн. | |
| 4.1.3.2 | Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлэг гаргагчийн тоо | 2021 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулсан байна. | Албан хаагчдын ХАСХОМ мэдүүлгийг бөглүүлж meduuleg.iaas.mn хаягт хугацаанд нь илгээж баталгаажуулсан. Хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх маягтыг албан хаагчдад тарааж, мэдүүлэх бөглөх тохиолдлууд, бөглөөгүйгээс болон зөрчнөөс үүсэх үр дагаврын мэдээллийг 2024 онд албан хаагчдад 6 удаа хүргэсэн. ЭБАТ-ын зүгээс тус газрын 11 албан хаагчийн 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр багтаан хянаж баталгаажуулан АТГ-т илгээсэн.<br>2024 оны байдлаар албан тушаал өөрчлөгдөж ХАСУМ хянуулсан албан хаагч байхгүй байна. | |
| 4.1.3.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Барилга эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, Барилга байгууламжийг байнгийн ашиглалтад хүлээж авах комисс ажиллах, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах гэх мэт үйл ажиллагаанд оролцож байгаа албан хаагчид Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг бөглөж байгууллагын ЭБАТ-аар хянуулсан нь 2024 онд 108 байна. ЭБАТ мэдэгдлийг хүлээн авч цаасаар болон meduuleg.iaac.mn хаягт бүртгээд байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3.4 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | Тус газарт 2024 оны байдлаар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд байхгүй байна. | |
| **4.1.4** | **Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал** | **78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан.** | **Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.** | | |
| 4.1.4.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | - | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна. | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг тухай бүр бүртгэж хэрэгжилтийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдөр аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 551 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| **4.1.5** | **Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **380 тушаал, 280 гэрээ, 1 журам, 1 эмхэтгэл** | **-** | **Тушаал болон гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгож бүртгэсэн байна. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан байна. Эмхэтгэл бэлэн болсон байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5.1 | Газрын даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тушаалын төслийн тоо | 2023 онд 183 тушаал гарч албажсан байна. | Газрын даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | 2024 оны 12 сарын байдлаар А/ дугаартай 60 тушаал, Б/ дугаартай 98 тушаал гарч албажаад байна. Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний зүгээс тушаалын үндэслэл хуулийн зүйл заалтыг тушаалын агуулгад нийцүүлэн боловсруулж батлуулсан. | |
| 4.1.5.2 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, албажуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын тоо | - | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | 2022 оны 03 дугаар сарын 22-ны А/07 дугаартай тушаалаар шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн байгууллагын хөдөлмөрийн додоод журам шинэчлэгдсэн. 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хуралдсан нийт хамт олны 05 дугаар хуралдаанаар байгууллагын ёс зүйн хорооны гишүүдийг сонгож мөн түүнчлэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдын эрх ашгийг хамгаалсан 4 төрлийн нэмэлт, 5 төрлийн нэмэлт өөрчлөлд оруулахаар хэлэлцэн баталж газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн "Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/34 дугаартай тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. | |
| **4.1.6** | **Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлал** | **Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор журам шинэчлэн батлагдсан.** | **Журманд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.6.1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээний тоо | 2023 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж, биелэлтийг үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | 2024 оны Төрийн жинхэнэ албан хаагчидтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж баталсан. Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрий "Үнэлгээний баг томилох тухай" А/29 дугаартай тушаалаар албан хаагчдын 2024 оны үнэлгээг шалгаж баталгаажуулах, газрын даргад дүгнэлт хүргэх үнэлгээний багийг нарийн бичгээс гадна сондгой тооны 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр журамд нийцүүлэн томилуулсан. Үнэлгээний багийн ирүүлсэн саналыг үндэслэн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/37 дугаартай тушаалаар шаардлага хангасан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. 2024 оны жилийн эцсийн албан хаагчдын үнэлгээ хянагдаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.7** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдалтын хувь** | **-** | **Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.** | Улсын хэмжээнд 2003-2023 онд иргэн, хуулийн этгээдэд олгосон бүх газарт хяналт шалгалт хийх ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/17 дугаартай удирдамжаар батлагдсан ГЗБГЗЗЕГ-ын Геодези зурагзүйн хэлтсийн дарга З.Мөнхцэцэг, Захиргааны хэлтсийн мэргэжилтэн н.Мөнхзул, Суурь судалгааны хэлтсийн мэргэжилтэн н.Сайнцогт нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2024 оны 03 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд Өгийнуур, Цэнхэр суманд ажиллав. Ажлыг хэсэг 2003-2023 онуудад иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлсэн Өгийнуур сумын 1324, Цэнхэр сумын 2192 нэгж талбарыг тухайн жилийн төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын захирамж гарсан эсэх, газар олголтыг газар дээр нь хэмжилт хийж бүхэлд нь шалгасан. Энэхүү хяналт шалгалтад тус газрын ГУХ-ийн бие бүрэлдэхүүн бүрэн оролцож хамтран ажилласан.<br>Мөн Тариат сумын ИТХ-ын дарга Д.Өлзийсайханы 2023 оны 12 дугаар 22-ны өдрийн 32 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтэд дурдсан, мөн бусад асуудлын дагуу тус газрын даргын 127 дугаартай томилолтын үнэмлэхээр ГХБХБГ-ын ГУХ-ийн ахлах мэргэжилтэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.7.1 | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сумдын тоо | - | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | ГГЗЗХУБайцаагч Өргөх механизмын хяналтын улсын байцаагч, Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэй Тариат сумын Хорго багт 2023 оны 12 дугаар сарын 25-26-ны өдөр мөн 2024 оны 03 дугаар сард 2 удаа хяналт шалгалтаар ажилласан.<br>Илэрсэн зөрчил дутагдлыг ажлын хэсгийн дүгнэлтээр газрын даргад хүргүүлсэн. Тус газрын захиргааны зүгээс дүгнэлтэд дурдсан зөрчлийг үндэслэн Тариат сумын газрын даамалд сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн зохион байгуулж газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн "Ажлаас чөлөөлөх тухай" Б/46 дугаартай тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж холбогдох арга хэмжээ авсан. | |
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | | **2021 онд 5 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.** | 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Газрын даргын тушаалаар Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан "Бүтээлч ажил"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газраас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж 70 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүсэн. Төлөвлөгөөнд 5 ажлыг үр бүтээлтэй хэргжүүлэхээр тусгасан.<br>1. Эрдэнэбулган, Булган сумын нутаг Бор өндөр уулын хэсэгчилсэн төлөвлөлтөд 100 сая, Өндөр-Улаан сумын Бэлхи, Донгой багийн хэсэгчилсэн төлөвлөлтөд 54 сая төгрөг суулгаж тендэр зарласан<br>2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 58 сая төгрөгийн өртөгтэй Киоски машин худалдаж авахаар "Ньюкомпас" ХХК-тай гэрээ байгуулж, аймгийн төвд ГХБХБГ, Тариат, Эрдэнэмандал сумдад 4 ширхэг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.8.1 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан "Бүтээлч ажил"-ыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Бүтээлч ажлын тоо, Хэрэгжилтийн байдал | - | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө болон зарлагдсан бүтээлч ажлуудыг орон нутагтаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэбулган суманд 19.8 сая төгрөгийн 1, нийт 5 ширхэг HS8044-A09 маркийн Киоски төхөөрөмжийг 2024 оны 6 дугаар сарын 04 ний өдөр хүлээн авсан. Эдгээр 45киоски төхөөрөмжийг суурилуулснаар иргэд олон нийтэд нэг цэгээс газрын мэдээллээ авах боломжийг бүрдүүлсэн. Хэрэгжилт 100%<br>3. Хайрхан, Хотонт, Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тендэрт "Инженер геодези" ХХК, Төвшрүүлэх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тендэрт "Циркул проект" ХХК-ууд шалгарч 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Хэрэгжилт 100%<br>4. 15 сумын 18719 нэгж талбарын хувийн хэргийг 209854 хуудас материалыг аймагт төвлөрүүлсэн.<br>5. Эрдэнэбулган сумын гэр хороололын гудамж талбай, аж ахуйн нэгж, байгууллагын хаягжуулалтыг "Юнител" ХХК-тай хамтран шинэчлэхээр уулзалт ярилцлага зохион байгуулж гудамж, зам талбай орон сууц, хашааны тоог зургийн хамт гаргаж өгөн хамтран ажиллаж байна.<br><br>Мөн "Бүсчилсэн хөгжил-Хариуцлагатай газрын харилцаа аяны хүрээнд" 2024 оны 03 дугаар сарын 18-с 22-ны өдрүүдэд Булган, Хотонт, Төвшрүүлэх сумдын ЗДТГын албан хаагчид, 05-р сарын 24-27-ны өдрүүдэд Б.Отгонцэрэн мэргэжилтний хамт 3 дугаар сургууль, спорт цогцолбор сургуулийн багш, албан хаагчдад нийт 89 иргэнд egazar.gov.mn-д хандан газрын харилцааны үйлчилгээ хэрхэн авах, төлөвлөгөөнд хэрхэн санал өгөх вэ, шинээр газар авах хүсэлт илгээх, дуудлага худалдаанд оролцох, газрын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлбөрийн мэдээлэлээ хэрхэн харах болон газрын төлбөрийн нэхэмжлэлийн дагуу цахим төлөлтийг хэрхэн хийх талаар мэдээлэл зөвлөмжийг өгөв.<br>2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Өндөр-Улаан сумын Малчдын зөвлөгөөн-Намрын ногоон өдрүүд өдөрлөгт сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчид, ХААИС-н багш нар Бэлчээрийн менежмент хийх аргачлалын талаар,тус газрын мэргэжилтэн А.Баярмаа, Н.Ариунзаяа газрын харилцааны цахим шилжилт, газрын дуудлага худалдаанд хэрхэн оролцох,төсөл сонгон шалгаруулалтад хэрхэн оролцох, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах үе шат, хэрхэн санал өгөх, цахим хүсэлт хэрхэн гаргах, EGAZAR.GOV.MN сайтад хандах, газрын харилцааны чиглэлээр үйлчилгээг хэрхэн авах талаар мэдээлэл өгсөн.<br>Мөн шинэ хоршоо хөдөлгөөн"-ний бүсийн уулзалтад оролцож ГЗБГЗЗЕГ-ын мэргэжилтэн болон тус газрын дарга 385 хүнд мэдээлэл хийсэн<br>-Хотонт, Цэнхэр, Төвшрүүлэх, Булган, Өндөр-улаан сумдад Цахим газрын харилцааны талаар сурталчилгаа хийсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.9** | **Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.** | **Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | | |
| 4.1.9.1 | Батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо | - | "Салбарын хэмжээнд байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/02 дугааартай тушаалын хоёрдугаар хавсралтаар тус газрын 2024 оны "Сургалт хөгжлийн төлөвлөгөө" батлагдсан. Төлөвлөгөөгөөр уулзалт зөвлөгөөн 4, албан хаагчид газрын даамлуудад зориулсан сургалт 10, албан хаагчид газрын даамлуудад зориулсан сургалт бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх сургалт 10 нийт 24 сургалт төлөвлөгдсөн хэрэгжилт 100 хувьтай байна. Төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдөр газрын даргын 551 дугаартай албан бичгээр аймгийн ЗДТГ, газрын даргын 550 дугаартай ГЗБГЗЗГ-т тус тус хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.9.2 | Салбарын хууль тогоомжийн хүрээнд ГХБХБГ-ын албан хаагчдыг болон сумдын газрын даамлуудыг мэргэжил арга зүгээр хангаж, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон салбарын хууль тогоомжийн хүрээнд байгууллагын албан хаагчид, сумын газрын даамлуудад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүгээр хангаж ажилласан байна. | 1. Сумын газрын даамлуудад ГКМС дээр ажиллах арга зүйн зөвлөгөө, зааварчилгааг өдөр тутам өгч ажиллаж байгаа бөгөөд нийтийг хамарсан цахим сургалтыг 2024 оны 4 дүгээр сарын 16 ны өдөр, 6 дугаар сарын 07 ны өдөр цахим сургалтыг зохион байгуулж, 19 сумын газрын даамал давхардсан тоогоор 60 хүн хамрагдсан.<br>2. 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр сумын газрын даамлуудад Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд, Газрын харилцааны талаар цаашид анхаарах зүйлийн талаар ГХБХБГ-ын дарга, ГУХ-ийн дарга нар илтгэл мэдээлэл өгч, Газар зохион байгуулалт хийх журмын талаар мэдээлэл хийж, Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар мэдээлэл сонсож, цахим системд тулгарч байгаа асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.<br>3. ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Малчдын хоршооны талаарх сургалт, уулзалтанд сумдын удирдлага, даамлыг зохион байгуулж хамруулсан.<br>4. Малчдын хоршоонд олгох 5 га газрын талаар ГЗБГЗЗЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр сумын даамлуудад цахимаар сургалт зохион байгуулсан.<br>5. 2024 оны 05-р сарын 06-ны өдөр сумын газрын даамлуудад Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд, Газрын харилцааны талаар цаашид анхаарах зүйлийн талаар ГХБХБГ-ын дарга, ГУХ-ийн дарга нар илтгэл мэдээлэл, Төрийн албаны Архангай аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичиг Ж.Эрдэнэтуяа “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр анхаарах асуудлаар мэдээлэл сонсож, газрын төлбөр, татварын цахим систем, газрын биржийн цахим системийн үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаанд тулгарч байгаа асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.<br>6. ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Малчдын хоршооны талаарх сургалт, уулзалтанд сумдын удирдлага, даамлыг зохион байгуулж хамруулсан.<br>7. Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт, хийх журам" шинэчлэн батлагдсантай холбоотой 21 аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар зохион байгуулалт, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгууллаа. | |
| 4.1.10 | **Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх** | **Үйл ажиллагаа** | - | - | **Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.** | 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Барилгын салбарын инженер, техникийн ажилчдын зөвлөгөөн - 2024" арга хэмжээ, 2024 оны 03-р сарын 18-ны өдөр Газрын даргын удирдамжаар "Бүсчилсэн хөгжлийг дэмжих хариуцлагатай газрын харилцаа" аяны хүрээнд Булган, Ихтамир, Өндөр-Улаан, Төвшрүүлэх, Цэнхэр сумын нийт 150 гаруй иргэдэд Хот байгуулалтын кадастрын цахим системын талаар болон Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн тухай мэдээлэл хүргэв.<br>Мөн Архангай аймгийн ГХБХБГ-ын цахим хуудсаар дамжуулан иргэд аж ахуй нэгжүүдэд Urban.gov.mn цахим системийг олон нийтэд тогтмол сурталчилж байна.<br>Түүнчлэн иргэн, ААНБ QR кодыг уншуулан Egazar.gov.mn-д нэвтрэх заавар, газрын төлбөр төлөх зааврыг цахимаар харах боломжийг бүрдүүлэн байгууллагын цахим буланд байршуулж иргэд олон нийдэд сурталчилж мэдээлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.10.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан. | Салбарын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулж, нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Өндөр-Улаан сумын Малчдын зөвлөгөөн-Намрын ногоон өдрүүд өдөрлөгт сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчид, ХААИС-н багш нар Бэлчээрийн менежмент хийх аргачлалын талаар,тус газрын мэргэжилтэн А.Баярмаа, Н.Ариунзаяа газрын харилцааны цахим шилжилт, газрын дуудлага худалдаанд хэрхэн оролцох,төсөл сонгон шалгаруулалтад хэрхэн оролцох, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах үе шат, хэрхэн санал өгөх, цахим хүсэлт хэрхэн гаргах, EGAZAR.GOV.MN сайтад хандах, газрын харилцааны чиглэлээр үйлчилгээг хэрхэн авах талаар мэдээлэл өгсөн.<br>"Бүсчилсэн хөгжил-Хариуцлагатай газрын харилцаа аяны хүрээнд" 2024 оны 03-р сарын 18-с 22-ны өдрүүдэд Булган, Хотонт, Төвшрүүлэх сумдын ЗДТГын албан хаагчид, 05-р сарын 24-27-ны өдрүүдэд Б.Отгонцэрэн мэргэжилтний хамт 3 дугаар сургууль, спорт цогцолбор сургуулийн багш, албан хаагчдад нийт 89 иргэнд egazar.gov.mn-д хандан газрын харилцааны үйлчилгээ хэрхэн авах, төлөвлөгөөнд хэрхэн санал өгөх вэ, шинээр газар авах хүсэлт илгээх, дуудлага худалдаанд оролцох, газрын төлбөрийн мэдээлэлээ хэрхэн харах болон газрын төлбөрийн нэхэмжлэлийн дагуу цахим төлөлтийг хэрхэн хийх талаар мэдээлэл зөвлөмжийг өгөв. | |
| **4.1.11** | **Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагааны зардал** | **Баримт бичиг** | **2022 онд 3600 албан бичиг, 500 өргөдөл, гомдол хүлээн авсан.** | **Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдолыг "Байгууллагын удирдлагын цогц цахим систем"-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.** | Тус байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас тус газарт ирүүлсэн өргөдөл хүсэлт, албан бичгүүдэд дараалын дагуу дугаар өгч, даргад танилцуулан заасан нэгжид шилжүүлж, албан бичиг, өргөдөл хүсэлтийг хугацаандаа шийдвэрлэхэд нь хяналт тавин ажиллаж байна. | |

## ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.1.8.1 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан “Бүтээлч ажил”-ыг хэрэгжүүлэх | Бүтээлч ажлын тоо, Хэрэгжилтийн байдал | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө болон зарлагдсан бүтээлч ажлуудыг орон нутагтаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Эрдэнэбулган сумын Бор-Өндөр, Арцатын амын орчимд шинэ суурьшлын бүс 100 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах<br>Хайрхан, Эрдэнэбулган, Ихтамир, Тариат, Эрдэнэмандал сум, аймгийн ГХБХБГ-т нийт 6 газрын харилцааны киоск машин хэрэглээнд нэвтрүүлнэ,<br>Хайрхан, Булган, Төвшрүүлэх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулна,<br>Аймгийн 19 сумын нэгж талбарын хувийн хэргийг аймгийн ГХБХБГ-ын архивт 100 хувь татан тавларуулэх ажил зохион байгуулна,<br>Эрдэнэбулган сумын гэр хороололын гудамж талбай, аж ахуйн нэгж , байгууллагын хаягжуулалтын “Юнител” ХХК-тай хамтран зохион байгуулах |
| 4.1.11.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо, Өргөдлийн тоо, Тайлангийн тоо | - Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>- Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>- Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна. | Тус байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас тус газарт ирүүлсэн өргөдөл хүсэлт, албан бичгүүдэд дараалын дагуу дугаар өгч, даргад танилцуулан заасан нэгжид шилжүүлж, албан бичиг, өргөдөл хүсэлтийг хугацаандаа шийдвэрлэхэд нь хяналт тавин ажиллаж байна.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон тус газрын ажилтнуудаас бичгээр хандсан өргөдөл 299 хүлээн авснаас 288 хүсэлтийг зохих хууль журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэж 11 өргөдөл, хүсэлт хугацаандаа судлагдаж байна.<br>Өргөдөл гомдлын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст улирал бүр хүргүүлэн ажилладаг бөгөөд 1 дүгээр улирлын мэдээг газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар албан бичгээр, 2 дугаар удиралын тайланг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 505 дугаартай албан бичгээр, 3 дугаар улирлын мэдээг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, 4 дүгээр улиралын мэдээг 11 дүгээр сарын 29-ны өдөр gunerdene@arkhangai.gov.mn хаягаар тус тус хүргүүлсэн .<br><br>Явуулсан албан бичиг:<br>Удирдах дээд байгууллагууд болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичгийн хариу тус байгууллагаас хандсан, нийт 1097 албан бичиг хүргүүлсэн байна.<br>Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдал: Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн албан бичиг нийт 1145 бичиг хүлээн авснаас 1131 албан бичгийн хариу болон зохих хууль журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэж, 14 албан бичиг хугацаандаа судлагдаж байна. |
| 4.1.12.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Хадгаламжийн нэгжийн тоо | 2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна.<br>2024 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадагаламжийн нэгж үүсгэн архивласан байна. | 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хөтөлж дууссан баримтыг архивлан 28 хадгаламжийн нэгж үүсгэсэн байна. |
| | Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж дотоод ажлыг зохион байгуулах | Өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн тоо, оролцоо | Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдсан байна. | Баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, монгол хэлний зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлж, албан ёсны хүчинтэй байдлыг хангаан боловсруулж, хянуулах, батлуулах чиг үүргийг хэрэгжүүлж тус байгууллагад иргэн, аж ахуйн, нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл хүсэлтийг бүртгэн хугацаатай шийдвэрлэгдэж буйд хяналт тавин ажиллаж байна . |
| 18 | Жил, улирал, сарын гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж хэрэгжилтийг хангах, тайлагнах | Батлуулсан төлөвлөгөө, тайлагнасан тайлангийн тоо | Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна. | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргатай байгуулан батлуулж улирал тутам тайлагнах ажиллаж байна. |
| 19 | Байгууллагын хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан | Гүйцэтгэсэн ажил, тайлагнасан тайлангийн тоо | Хамрагдсан хурал, уулзалт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан, тайлагнагдсан байна. | Өргөдөл, гомдлын тайланг улирал тутам аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлдэг ба 2024 оны 1 улиралын тайланг 02 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаартай албан бичгээр 2 дугаар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.12.2 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:** Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна. **Жилийн эцэст:** Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01 дугаартай хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод баримт бичгийн стандартын дагуу боловсруулах, баримт бичгийг заавар дагуу эмхлэн цэгцэлж, байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй хүлээлгэн өгч, нөхөн бүрдүүлэлт хийж байх талаар тусгасны дагуу албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх ойлголт, нэмэгдүүлсэн сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 19-ны өдөр байгууллагын албан хаагчдыг зохион байгуулан улсын үзлэгийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хугацаат ажилууд хийгдэж байна. | |
| **4.2.1** | **Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх** | • | **Санхүүгийн хяналт шалгалтын дүн** | **Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод тайлагнаж ажилладаг.** | **Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.** | | |
| 4.2.1.1 | Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна. | 2024 оны 11 сарын 30-ны байдлаар 1,280,343,9 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авч төсвийн сар улирлын хуваарийн дагуу зарцуулж 114,665.8 мянган төг үлдэгдэлтэй хэмнэлт гарган байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулж байна. Орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 113,075.1 мянган төгрөг төлөвлүүлж жилийн эцсээр 100% биелэхээр байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1.2 | Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | 2023 санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын зөрчилгүй санал дүгнэлт гаргуулж 03 сарын 06-нд газрын даргын 190 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. 2024 оны хагас жилийн тайланг хугацаанд нь гаргаж ГЗБГЗЗЕГазарт 07 сарын 19-нд 615 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.. Жилийн эцсийн тайланг санхүүгийн тайлангийн жил дуусгавар болгож 2 дугаар сарын 25-ны дотор хийж аудитын дүгнэлт гаргуулна. | |
| 4.2.1.3 | Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна. | 2024 оны жилийн эцсээр төсвийн зардал тус бүрээр хэтрэлтгүй ажилласан. Өр авлага үүсгээгүй. | |
| 4.2.1.4 | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна. | Байгууллагын даргын 2024 оны 06сарын 10-ны А/35 дугаартай тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдон үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг тушаалд заасан хугацаанд хийж гүйцэтгэлээ. Жилийн эцсийн тооллогыг 12 сарын 10-нд хийхээр төлөвлөж байна.Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг актлах мөн үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах хүсэлтийг газрын даргын 2024 оны 11 сарын 14-ны 1027 дугаартай албан бичгээр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1.5 | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн хугацааг хоцроохгүй байх. | Байгууллагын хэвийн үйл ажиллааг ханган өдөр тутмын гүйлгээг цаг хугацаанд хийн мөн НДШ тайланг сар бүрийн 5-ны дотор ,таварын тайланг улирал бүр, Төрийн өмчийн тайланг цаг хугацаанд нь хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 2-ны дотор дээд шатны байгууллага ГЗБГЗЗЕГазрын санхүүгийн албан хүргүүлж байна.Төсвийн ил тод байдлыг хангаж шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрт хугацаанд нь 11 сарын 30 - наар 151 мэдээлэл оруулсан байна. | |

----oOo----